

## ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

### Тавигдах болзол, шаардлага:

- Төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- Зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- Зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

### Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангарагийн хуудас” хуулбар;
- Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–аас татан авах/;
- Тухайн орон тоонд шилжин ажиллахыг хүссэн өргөдөл.

### Материал хүлээн авах:

- Хугацаа: 2026 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 09:00 цагаас 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 17:00 цаг хүртэл
- Хүлээн авах хаяг: [taz\\_enkhchimeg@burtgel.gov.mn](mailto:taz_enkhchimeg@burtgel.gov.mn) цахим шуудангаар
- Холбоо барих утас: 11321242, 99007339

Шилжүүлэх, сэлгэн авах ажлын байрны жагсаалт

№	Байгууллага	Дотоод нэгж	Албан тушаал	Орон тоо	Албан тушаалын		Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага			
					төрөл	Ангилал, зэрэглэл	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага
1	Улсын бүртгэлийн ерөнхий газар	Санхүү, үйлчилгээний хэлтэс	Төсөв, худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн	1	Гүйцэтгэх	Дэс түшмэл	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх	- нягтлан бодох бүртгэл /0411/; - санхүү /0412/; - эдийн засаг /0311/; - бизнесийн удирдлага /041301/.	Шаардахгүй.	Шаардахгүй

---oOo---